

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам”, байгууллагын Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 01-08/08 дугаар удирдамжийг үндэслэн 2024 оны гуравдугаар улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр төлөвлөгөөт, сар бүр явцын хяналт тавьж ажиллалаа.

Байгууллагуудыг дэлгэрэнгүйгээр өссөн дүнгээр харуулбал:

д/д	Байгууллагууд	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Мэдээлэх давтамж	Хугацаандаа	Хугацаа хоцорсон мэдээлэл	Хугацаа болоогүй	Хувь
1	2	3	4	5	5	6	7
1	Гадаадын иргэн, харьяатын газар	1	135	135	-	-	100.0
2	Агаарын замын боомт хариуцсан газар	1	135	135	-	-	100.0
3	Дорноговь аймаг дахь газар	1	135	135	-	-	100.0
4	Хойд бүс дэх газар	1	135	134	1	-	99.2
5	Өмнөд бүс дэх газар	1	135	135	-	-	100.0
6	Баруун бүс дэх газар	1	135	134	1	-	99.2
7	Зүүн бүс дэх газар	1	135	135	-	-	100.0
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	135	135	-	-	100.0
Нийт дүн		8	1080	1078	2	-	99.8

Тус шалгалтаар төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтын зохих мэдээллийг анхан шатны баримтад үндэслэн гуравдугаар улиралд байгууллагын хэмжээнд цахим хуудсанд 1080 мэдээлэл байршуулахаас 1078 мэдээллийг байршуулж 99.8 хувийн үзүүлэлттэй “ХАНГАЛТТАЙ” үнэлэгдэж байгаа хэдий ч сар, улирлаар хийгдсэн хяналт шалгалтаар зарим мэдээллийг дутуу байршуулсан зөрчил удаа дараа гарч байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

2024 оны гуравдугаар улирлын хяналт, шалгалтаар Өмнөд бүс, Баруун бүс дэх газар, Хойд бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс холбогдох мэдээллийг дутуу байршуулсан зөрчил дахин илэрч байгаа нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн даргын 2024 оны 09/04, 09/14 дугаар дотоод албан бичгийн хэрэгжилт, зөвлөмж хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, байршуулж буй мэдээллийн чанар, агуулга, үнэн зөв, иж бүрэн байдалд анхаарал хандуулж ажиллах;
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг өссөн дүнгээр мэдээллэх;
- Дотоод аудитын зөвлөмж, удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан, түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах тул эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандан холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтний jargalmaa.l@immigration.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

---oooOoo---